

## “ЭХ ХЭЛНИЙ ӨДӨР” ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ЗОХИОН БАЙГУУЛСАН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2023.09.10


Дархан-Уул аймаг

“Эх хэлний өдөр”-ийг угтан иргэдийн эх хэлний боловсролыг дээшлүүлэх, үндэсний бичгийн уламжлал түүхээ танин мэдэх, энэхүү соёлын өвөөрөө бахархах үзлийг төлөвшүүлэх, нийгмийн сэтгэл зүйг бэлдэх зорилгоор “Үндэсний бичгээ сурч, хос бичигтэн болох” уриалгыг аймгийн Соёл, урлагийн газар болон сумын Соёлын төвүүдийн цахим пэйж хуудсаар олон нийтэд түгээж мөн 2025 оноос төрийн албан хэргийг кирилл болон үндэсний бичгээр хөтлөн явуулахтай холбогдуулан соёлын байгууллагуудын албан хаагчид манлайлан үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх олон талт ажлыг зохион байгуулж ажиллалаа.


Тус газраас харьяа 7 байгууллагад “Эх хэлний өдөр”-ийг угтан үйл ажиллагаа зохион байгуулж тайланг хугацаандаа өгөх үүрэг чиглэлийг өгч ажилласан. Үүний дагуу “Эх хэлний өдөр”-өөр аймгийн соёл, урлагийн газар болон харьяа соёлын 7 байгууллага нийт 21 үйл ажиллагаа зохион байгуулж 508 иргэд олон нийтийг хамруулж цахим соёлоор 8433 хүний хандалтыг авсан байна. Үүнд:

### Аймгийн Соёл, урлагийн газар


1. Соёлын яамнаас “Эх хэлний өдөр”-ийг тохиолдуулан “Үндэсний хэлээ сурч, хос бичигтэн болцгооё” уриалгыг харьяа соёлын байгууллагууддаа түгээж байгууллагын пэйж хуудсаар аймгийн иргэд, олон нийтэд хүргэж ажиллалаа. Мөн Монгол хэлний дархлааг улам сайжруулах шаардлагатай байгаа тухай мэдээллийг харьяа байгууллага болон аймгийн иргэд олон нийттэй хуваалцлаа. /Нийт-22 үзэгч олон нийтэд хүрсэн/



2. "Эх хэлний өдөр"-ийг тохиолдуулан Төв номын сан, Хүүхдийн номын ордноос аймгийн иргэдэд зохион байгуулах үйл ажиллагааны хөтөлбөрийг нэгтгэн байгууллагын цахим, пэйж хуудсанд нийтэлсэн. /Нийт 31 үзэгч олон нийтэд хүрсэн/



3. Үндэсний бичгээ сурч, хос бичигтэн болох” уриалгын хүрээнд Дархан-Уул аймгийн Соёлын биет бус өвлөн уламжлагч, аймгийн 30 дугаар сургуулийн сургалтын менежер Ж.Эрхэмсайхан багш Монгол хэл бичиг хэзээ үүссэн тухай, Монгол бичгийн хуйлмал ном бүтээсэн тухай нэвтрүүлгийг Монцамэ агентлагийн Дархан дахь хэвлэл мэдээллийн ажилтантай хамтран “Эх хэлний өдөр”-өөр байгууллагын пэйж хуудсанд байршуулж, иргэд олон нийтэд хүргэлээ. /Нийт 44 үзэгч олон нийтэд хүрсэн/



4. 2017 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн 25 дугаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар жил бүрийн 09 дүгээр сарын 01-ний өдрийг эх хэлний өдөр болгон зарласан. Энэ хүрээнд бүх нийтээр эх хэлний өдрийг угтан Монгол хэлний хэм хэмжээг дагаж мөрдөх, хос бичигтэн болох, олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллагууд эх хэлээ сурталчлах, түүгээр бахархах, олон нийтэд түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн эх хэл, соёл, түүх, зан заншил, өв уламжлалын тухай мэдээ мэдээлэл, нийтлэл, нэвтрүүлгийг тус газар “Эх хэлний өдөр”-ийг тохиолдуулж цахим, пэйж хуудсанд **нийт 10** зурагт хуудас, видео бичлэгийг байршуулж **32** хүний хандалтыг авсан байна. /Нийт 4 арга хэмжээ зохион байгуулж 129 иргэд олон нийтэд хүрсэн байна/

**Аймгийн Музей****ЭХ ХЭЛНИЙ ӨДӨРТ ЗОРИУЛАН ДЭГЛЭСЭН “ЭХ ХЭЛ БИДНИЙ  
БАХАРХАЛ” ТҮР ҮЗЭСГЭЛЭНГИЙН ТАЙЛАН**

“Эх хэлний өдөр”-ийг угтан иргэдийн эх хэлний боловсролыг дээшлүүлэх, үндэсний бичгийн уламжлал түүхээ танин мэдэх, энэхүү соёлын өвөөрөө бахархах үзлийг төлөвшүүлэх, нийгмийн сэтгэл зүйг бэлдэх зорилгоор “Үндэсний бичгээ сурч, хос бичигтэн болох” уриалгыг хэрэгжүүлэх үүднээс аймгийн Музей нь дараах үйл ажиллагааг зохион байгууллаа.


2023 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр “Эх хэлний өдөр”-ийг тохиолдуулан аймгийн Музейн сан хөмрөгөөс “Эх хэл бидний бахархал” түр үзэсгэлэнг үзэгч олон нийтэд толилуулав. Уг үзэсгэлэнд 30 дугаар сургуулийн Д.Эрхэмсайхан багшийн бичсэн монгол бичгийн зурлага, уран бичлэгийн хэлбэрүүд, өлзийт султаны бичиг, дээрхийн гэгээнтэн арван долдугаар Далай ламын “Хүн төрөлхтөнд зориулсан шинэ мянганы айлдвар”-аас, Д.Пүрэвдорж “Чингис” шүлэг, О.Дашбалбар “Амьддаа бие биенээ хайрла” шүлэг, Б.Ринчен “Монгол хэл” шүлэг, Д.Равжаа “Дөрвөн улирал, Чингисийн чулууны бичиг зэрэг нийт 22 бүтээлүүдийг дэглэсэн бөгөөд **39** том хүн / БНХАУ-ын жуулчин/, **25** хүүхэд үзэж танилцав. /Нийт 1 үйл ажиллагаа зохион байгуулж **64** иргэд олон нийтийг хамруулав/



## Төв номын сан

“Эх хэлний өдөр”-ийг угтан иргэдийн эх хэлний боловсролыг дээшлүүлэх, үндэсний бичгийн уламжлал түүхээ танин мэдэх, энэхүү соёлын өвөөрөө бахархах үзлийг төлөвшүүлэх, нийгмийн сэтгэл зүйг бэлдэх зорилгоор “Үндэсний бичгээ сурч, хос бичигтэн болох” уриалгыг хэрэгжүүлэх үүднээ аймгийн Төв номын сан доорх ажлуудыг тус тус тусган ажиллалаа. Энэ хүрээнд тус өдрийг угтан Багш сурган хүмүүжүүлэгчдэд зориулсан номын үзэсгэлэн 127 нэр төрлийн 127 боть номоор Эх болох ардын аман зохиол онч мэргэн үгс зүйр цэцэн үгс оньсого тааврын 236 нэр төрлийн 236 боть номоор сэдэвчилсэн номын үзэсгэлэн гаргалаа.

Мөн монгол ардын аман зохиолын тод түргэн хэллэг, мэргэдийн сургаал, онч мэргэн үгс, ертөнцийн гурваас сурталчилан таниулах зорилгоор хэвлэн гарган сурагчдад үзүүлэн таниулах сурталчилгаа хийж Төв болон салбар номын сангийн танилцуулагыг 15 дугаар сургууль болон Од цогцолбор сургуулийн **6 ангийн нийт 247** сурагчдад хийж идэвхтэй уншлагыг зохион байгууллаа. “Эх хэлний өдөр”-өөр ардын аман зохиолын охь болсон тод түргэн хэллэг, онч мэргэн үгс, зүйр цэцэн үгс, оньсого тааврын уралдааныг зохион байгуулж 25 сурагчдыг гарын бэлгээр урамшуулж ажиллалаа. Хүүхдийн зохиолч О.Сундуйн “Тэнгэрт өлгөөтэй бяслаг” номноос “Бичиг мэддэггүй бамбарууш” үлгэрээр чанга уншлага хийж, “Ганган зараа” шүлгийг уншин өгч утга санааг харилцан ярилцан соёл танин мэдэхүй ажлыг тус тус хийлээ. Тус өдрөөр Төв номын сангаас “Хүүхэд залуучуудыг Монгол хэл, бичгийн хичээлээ шимтэн суралцаж, зөв сайхан ярилцаж, бичиж, шүлэг яруу найраг, ном зохиолоо уншиж, агуу түүхт бичгийн соёлоо дээдэлж, хамгаалах”-ыг уриалж видео бичлэг хийн байгууллагын пэйж хуудсаар иргэд, олон нийтээд байршуулж уриаллаа. /**Нийт 6 үйл ажиллагаа зохион байгуулж 247 хүүхдийг хамруулж цахимаар 88 иргэд олон нийтэд цахим соёлыг түгээсэн/**



## Хүүхдийн номын ордон

Монгол улсын ерөнхийлөгчийн 2017 оны 25 тоот зарлигийн хэрэгжилтийг хангах, Эх хэл, түүх соёлоо сурталчлах, эх хэлээрээ зөв ярьж, цахим орчинд зөв бичих дадал хэвшүүлэх зорилтыг дэвшүүлэн дараах ажлуудыг зохион байгууллаа.

### **Эх хэл, түүх соёлоо сурталчлах;**

1.“Эх хэлний өдөр”-ийг тэмдэглэх арга хэмжээний хүрээнд “Үндэсний монгол бичгээ сурч, хос бичигтэн болцогооё” уриан дор монгол бичгээр шамдан суралцагч хүүхэд багачуудын “Бийрийн бичлэгийн шилдэг бүтээл”-ийн болон ажилтан албан хаагчдын “Миний нэрийн хуудас” үзэсгэлэнг сэргээн шинэчилж гаргасан. Тус үзэсгэлэнг 1 дүгээр давхрын зааланд гаргаж, нийт **120** гаруй уншигч үзэж сонирхсон.



2. Өөрийн сан хөмрөг дэх тухайн чиглэлийн ном хэвлэлийг нийтэд сурталцах, номын эргэлтийг сайжруулах, хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор 32 боть номоор биет үзэсгэлэн гаргаж 1 дүгээр давхрын шилэн хоргонд байршуулсан. Мөн цахим хэлбэрт хувиргаж, пейж хуудсандаа байршуулж, **379** хэрэглэгчдэд түгээсэн.



3. “Эх хэлний өдөр”-ийг тохиолдуулан хичээлийн шинэ жилийн эхний өдөр ХНО-ны уншлагын танхимаар үйлчлүүлсэн 4-6 дугаар ангийн **17** хүүхдэд “Угийн бичиг гэж юу вэ?, хөтлөх арга, таних тэмдэг”-ийн талаар сургалт зохион байгуулж, дадлага ажил хийсэн.




1. Ордны пейжээр дамжуулан “Эх хэлний өдөр”-ийг тэмдэглэх арга хэмжээний хүрээнд:
  - ❖ “Зөв бичих арга зүйн зөвлөгөө” видео шторк
  - ❖ Салаа утгатай үг
  - ❖ Хатуу зөөлний тэмдэгийн дүрэм
  - ❖ Ижил дуудлагатай үгс
  - ❖ Хүндэтгэлийн үгс
  - ❖ Эх хэлний тухай танин мэдэхүйн мэдээлэл-4 тус тус бэлтгэн байршуулж, **4589** цахим хэрэглэгчдэд хүргэсэн.
2. “Зөв бичих арга зүй” сэдвээр мэдээлэл бэлтгэж, **35** уншигч хүүхдүүдэд мэдээлэл хийсэн.



3. Эх хэлээрээ зөв бичих дадал хэвшилд суралцах үйл ажиллагааг дэмжин “Зөв бичих арга зүйн зөвлөгөө” мэдээлэл бэлтгэж цахим хуудсандаа байршуулж **154** хэрэглэгчдэд хүргэсэн. /Нийт **5** үйл ажиллагаа зохион байгуулж **172** иргэд олон нийтийг хамруулж цахимаар **5122** үзэгч олон нийтэд хүргэсэн.

### **Шарын гол сумын Соёлын төв**

1. “Эх хэлний өдөр”-ийг тохиолдуулан “Үндэсний бичгээ сурч хос бичигтэн болцгооё” уриан дор богино хэмжээний дүрс бичлэг бэлтгэн Шарын гол сумын соёлын төв нь цахим хаягтаа байршуулсан-**1502** хандалттай байна.
2. Дархан-Уул аймгийн Соёл, урлагийн газраас ирүүлсэн дүрс бичлэгийг цахим хаягтаа байршуулсан **1115** хандалттай байна.
3. Хичээлийн шинэ жилийг угтаж, эх хэлний өдрийг тохиолдуулан сумын хүүхэд залуусдаа зориулж “Open mic”г **500** гаруй үзэгч сонсогчидтой найрамдал талбайд зохион явууллаа. /Нийт цахимаар **3** үйл ажиллагаа зохион байгуулж **3117** иргэд олон нийтэд түгээсэн./



**Хонгор сумын Соёлын төв**

“Эх хэлний өдөр”-ийг угтан иргэдийн эх хэлний боловсролыг дээшлүүлэх, үндэсний бичгийн уламжлал түүхээ танин мэдэх, энэхүү соёлын өвөөрөө бахархах үзлийг төлөвшүүлэх, нийгмийн сэтгэл зүйг бэлдэх зорилгоор “Үндэсний бичгээ сурч, хос бичигтэн болох” уриалгыг хэрэгжүүлэх үүднээс Хонгор сумын соёлын төв нь Эх хэлний өдрийг зарлах тухай Ерөнхийлөгчийн зарлигын дор тус сумын 14 дүгээр сургуулийн 9а ангийн 25 сурагчдад монгол хэл бичгээ сурталчлах, түүгээр бахархах, олон нийтэд түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн эх хэл, соёл, түүх, зан заншил, өв уламжлалын тухай мэдээ мэдээлэл, нийтлэл бэлтгэн соён гэгээрүүлэх ажлыг хийлээ. /1 арга хэмжээ зохион байгуулж 25 хүн хамрагдсан/.



**Орхон сумын Соёлын төв**

“Эх хэлний өдөр”-ийг угтан Орхон сумын ЕБС-ийн 8а ангийн сурагчдад С.Дулам “Хүмүүн бичиг” шүлгийн хэсгээс монгол хэлийг үндэсний монгол бичиг рүү хөрвүүлж уншууллаа. Монгол хүүхэд бүр эх хэлээ баттай эзэмшиж, бахархаж хөгжүүлэх түгээн дэлгэрүүлэх ариун үйлсэд элэг тавьж, өв соёл, түүх уламжлалынхаа эзэн байхын төлөө хичээнгүйлэн суралцажгааж хамтран ажилласан ЕБС-ийн Монгол хэл, бичгийн багш Цэрэнпагм багш хамтарч ажиллаа.

Мөн “Үндэсний бичгээ сурч хос бичигтэн болцгооё” уриан дор Соёлын яам болон аймгийн Соёл, урлагийн газраас зохион байгуулсан Эх хэлний өдөрт зориулсан зураг хуудаст, видео бичлэгийг байгууллагын пэйж хуудсанд байршуулан 65 иргэд, олон нийтэд хүргүүлж ажиллалаа.



ТАНИЛЦСАН:  
ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН  
ДАРГА Х.СОЁЛ-ЭРДЭНЭ

ТАЙЛАГНАСАН:  
ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН  
СОЁЛ, ГЭГЭЭРЛИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН  
МЭРГЭЖИЛТЭН Б.ДОЛГОРМАА